



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/111

Улаанбаатар хот

Хүйтний улирлын хувцсанд шилжүүлж,
хувцасны үзлэг зохион байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2, 30.3, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны "Цэргийн дүрэмт хувцас, цол, ялгах тэмдгийн загвар батлах тухай" 81 дүгээр зарлиг, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2017 оны "Дүрэм батлах тухай" А/493 дугаар тушаал, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн "Хүйтний улирлын хувцсанд шилжүүлж, хувцасны болон жагсаалын нэгдсэн үзлэг зохион байгуулах тухай" А/309 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Онцгой байдлын газрын бие бүрэлдэхүүнийг 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн хүйтний улирлын хувцсанд шилжүүлж, хувцасны үзлэгийг зохион байгуулсугай.

2. Нийслэлийн Онцгой байдлын газрын нийт бие бүрэлдэхүүнийг хүйтний улирлын хувцасны болон жагсаалын нэгдсэн үзлэгт Үндэсний Аврах бригадын жагсаалын талбайд 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 14.00 цагт бүрэн хамруулсугай.

3. Нийслэлийн Онцгой байдлын газрын бие бүрэлдэхүүнийг хүйтний улирлын хувцсанд шилжүүлж хувцасны үзлэг зохион байгуулах удирдамжийг хавсралтаар баталсугай.

4. Хүйтний улирлын хувцсанд шилжүүлж, хувцасны үзлэгийг зохион байгуулсан тухай нэгдсэн дүнг 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдөр танилцуулахыг Захиргааны удирдлагын хэлтэс (дэд хурандаа Б.Баттулга)-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус газрын Тэргүүн дэд, дарга (дэд хурандаа Н.Нямхорлоо)-д даалгасугай.

ДАРГА,
ХУРАНДАА

Ж.ЧҮЛТЭМСҮРЭН



D:/My documents-blank-2019-tushaal

00115050 819

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн
8/111 дугаар тушаалын хавсралт

1117155601
УХА0038 9077073

**НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ
ХҮЙТНИЙ УЛИРЛЫН ХУВЦСАНД ШИЛЖҮҮЛЖ, ХУВЦАСНЫ
ҮЗЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ**

Нэг: Зорилго

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны “Цэргийн дүрэмт хувцас, цол, ялгах тэмдгийн загварыг батлах тухай” 81 дүгээр зарлиг, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2017 оны “Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм батлах тухай” А/493 дугаар тушаал, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны “Хүйтний улирлын хувцсанд шилжүүлж, хувцасны болон жагсаалын нэгдсэн үзлэг зохион байгуулах тухай” А/309 дүгээр тушаалыг хэрэгжүүлэн нийслэлийн Онцгой байдлын газрын бие бүрэлдэхүүнийг хүйтний улирлын хувцсанд шилжүүлсэнтэй холбогдуулан алба хаагчдын хүйтний улирлын дүрэмт хувцасны жигдрэлт, хувцасны хангалт, гадаад үзэмж, цэрэгжилт, жагсаалч байдалд хяналт тавихад оршино.

Хоёр: Зохион байгуулах хугацаа

1. Нийслэлийн Онцгой байдлын газрын бие бүрэлдэхүүнийг 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн хүйтний улирлын хувцсанд шилжүүлж, хүйтний улирлын хувцасны үзлэгийг 10 дугаар сарын 22-ны өдрийн дотор зохион байгуулна.

Гурав. Шалгах чиглэл

- Бие бүрэлдэхүүний ирц
- Алба хаагчдын бичиг баримт, биед байх зүйлс
- Хүйтний улирлын дүрэмт хувцасны жигдрэлт, гадаад үзэмж, хангалт
- Жагсаалын дүрмийн мэдлэг

- Жагсаалын дүрмийн дагуу биеэр гүйцэтгэх ажиллагаа
- Дарга, захирагч нарын жагсаал удирдах ур чадвар

Дөрөв. Хувцасны үзлэгийн зохион байгуулалт

1. Нийслэлийн Онцгой байдлын газар, дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төв, нийслэлийн Аврах анги-105, Гал түймэр унтраах аврах ангийн алба хаагчдад хувцасны үзлэгийг тухайн нэгжийн дарга нар хариуцан зохион байгуулна.

2. Хувцасны үзлэгт алба хаагчид савхин дээл, китель, урт ханцуйтай цэнхэр цамц, ханцуйгүй ноосон цамц, зангиа, хавчаар, өвлийн малгай, ноосон ороолт, савхин бээлий, эмэгтэй алба хаагчид юбка, ноосон оймс, өвлийн түрийтэй гутал, бичиг баримт, биед авч явах зүйлстэй жагсана.

3. Хувцасны үзлэгээр илэрсэн ололт, дутагдлыг тусгасан, ирцийн дүн, хувцасны жигдрэлт, цаашид анхаарах асуудлын талаарх саналаа илтгэх хуудсанд нэгтгэж ирүүлнэ.

4. Хувцасны үзлэгт 2 буюу түүнээс дээш дутагдал гаргасан, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тасалсан алба хаагчдад холбогдох дүрэм журмын дагуу сахилгын арга хэмжээ тооцох.

Тав. Дүнг тайлагнах

1. Хүйтний улирлын хувцасны үзлэг зохион байгуулсан тухай мэдээг хавсралтад заасан загварын дагуу бөглөж илтгэх хуудсын хамт Захиргааны удирдлагын хэлтэст 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 18:00 цагт цахим хаягаар [/radnaa.munkh@gmail.com](mailto:radnaa.munkh@gmail.com) / болон бичгээр ирүүлнэ.